



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн
багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/26/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261628
Цахим хаяг:
bolormaaj@audit.gov.mn

Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр
Бага тойруу-3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр
дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн
талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-САГ/2015/26/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 04 дүгээр сарын 03-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 04 дүгээр сарын 08-наас 2015 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж /ТАБ-СТА-А-9/, аудитын тайланг хуулийн хугацаанд Ерөнхийлөгчийн тамгын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн захирагч нь “Монгол Улсын үндсэн хууль”, “Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай”, “Төсвийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Архивын тухай” хуулиуд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын эрхэм зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулж, Ерөнхийлөгчийг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, алсыг харсан, мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээгээр хангаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийн хөтөч байхад оршино.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 152 дугаар зарлигаар Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дүрмийг баталсан байна. Тус дүрмийн 1.1 “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн” ерөнхийлөн захирагч байна гэж заасан байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга П.Цагаан нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 2% буюу 134.2 сая төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 21-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан байна.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулдаг боловч эцсийн санхүүгийн тайлан мэдээг эксел файлаар буюу гараар бэлтгэдэг байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Ерөнхийлөгчийн тамгын газрын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт сул байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын төсвийн ерөнхийлөн захирагчид 2014 онд улсын төсвийн татаас санхүүжилтийн орлогоор 8,727.2 сая, өөрийн орлогоор 20.0 сая нийт 8,747.2 сая төгрөг батлагдсанаас 6,972.2 сая төгрөгийг зарцуулж, 494.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn сайтад Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний 26 дансдад уламжлалт болон хяналтын нийт 57 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан алдаатай илэрхийлэгдэх, улмаар тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангаж чадахгүй байх
- Нягтлан бодох бүртгэлд тавих хяналт алдагдах,
- Үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журмын заалт зөрчигдөх

Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого зэрэг дансанд ажил

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцад нэгтгэгдсэн Ерөнхийлөгчийн төсөв, Ерөнхийлөгчийн тамгын газар, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Агаарын бохирдлыг бууруулах ажлын албаны 2014 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийсэн бөгөөд илэрсэн алдаа, зөрчил болон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аккруэл суурьт болон мөнгөн суурьт шалгах баланс, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан бэлдээгүй, төсвийн 765.1 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүлж нэгтгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах заавар, аргачлал”-ыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан заавар, аргачлалын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

2. Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 43.5 сая төгрөгөөр зөрүүтэй, 13.7 сая төгрөгийн биет бус хөрөнгийн дүнг биет хөрөнгийн дүнгээс тусад нь тайлагнаагүй, Засгийн газрын оруулсан капитал дансанд Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 39.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан автомашиныг бүртгэсэн нь Сангийн сайдын 269 дугаар журмын заалтыг зөрчсөн зэрэг зөрчлүүд байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 83.2 сая төгрөгийн залруулга хийж, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн санхүүгийн тайланг 2015 оны эхний хагас жилээр залруулга хийх зөвлөмж өгөв.

3. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор илэрсэн бүртгэлд тусгагдаагүй 49.3 сая төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайлан болон бараа материалын тодруулга тайланд 49.3 сая төгрөгийн залруулга хийв.

4. Ерөнхийлөгчийн тамгын газрын нягтлан бодох бүртгэл нь “Acolous” санхүүгийн програмаар хийгддэг боловч эцсийн санхүүгийн тайлангуудыг эксел файлаар буюу гараар гаргаж байгаагаас тооцооллын алдаа гарч Төсвийн шууд захирагч болох Ерөнхийлөгчийн тамгын газрын 2014 оны санхүүгийн байдлын тайлангийн актив пассивын дүн 37.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 169.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 132.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 37.4 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Зөвлөмж

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий Аудитор санал болгож байна.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Менежментийн захидал

Асуудал 1

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Асуудал 2

Санхүүгийн тайлагналын талаар

Асуудал 3

Засгийн газрын оруулсан капитал дансны
бүртгэлийн талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АСУУДАЛ 1: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Ажиглалт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аккрузал суурьт болон мөнгөн суурьт шалгах баланс, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан бэлдээгүй, төсвийн 765.1 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүлж нэгтгэсэн зэрэг алдаа зөрчил гарсан байна.

Зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах заавар, аргачлал”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлдэх

Эрсдэл

Санхүүгийн нэгтгэсэн тайлан алдаатай илэрхийлэгдэх, улмаар тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангаж чадахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 2: Санхүүгийн тайлагналын талаар

Ажиглалт

Ерөнхийлөгчийн тамгын газрын нягтлан бодох бүртгэл нь “Asolous” санхүүгийн програмаар хийгддэг боловч эцсийн санхүүгийн тайлангуудыг эксел файлаар буюу гараар гаргаж байгаагаас тооцооллын алдаа гарч Төсвийн шууд захирагч болох Ерөнхийлөгчийн тамгын газрын 2014 оны санхүүгийн байдлын тайлангийн актив пассивын дүн 37.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Зөвлөмж

Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажиллах

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлд тавих хяналт алдагдах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 3: Засгийн газрын оруулсан капитал дансны бүртгэлийн талаар

Ажиглалт

Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 39.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан автомашиныг Засгийн газрын оруулсан капитал дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр журмын заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж

Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалаар “хөрөнгийг бодит үнэ цэнээр нь орлогоор бүртгэнэ. Дт Үндсэн хөрөнгө, Кт Орлого” гэсэн заалтын дагуу Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 2015 оны хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх

Эрсдэл

Үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журмын заалт зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА П.ЦАГААН
ТАНАА

2015.04.22 № 465
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

A. Zangad
А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	808,191,745.16	653,958,915.49
МӨНГӨН ХӨРӨНГӨ	125,400,448.77	0
Кассанд байгаа бэлэн мөнгө	125,400,448.77	0
Төгрөг	81,884,191.01	0
Нэмэлт санхүүжилт	43,516,257.76	0
АВЛАГА	3,961,960.00	137,109.19
Ажиллагчидтай холбогдсон авлага	0	137,109.19
Бусад авлага	3,961,960.00	0
Байгууллагаас авах авлага	3,961,960.00	0
БАРАА МАТЕРИАЛ	678,829,336.39	653,821,806.30
Түүхий эд материал	267,760,895.59	347,872,653.02
Тусгай зориулалттай материал	267,760,895.59	347,872,653.02
Бэлэн бүтээгдэхүүн	49,644,906.00	49,366,916.00
Хангамжийн материал	361,423,534.80	256,582,237.28
Бусад хангамжийн материал	361,423,534.80	256,582,237.28
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	545,662,271.01	621,223,790.18
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	545,662,271.01	621,223,790.18
Газар	0	0
Биет хөрөнгө	538,763,937.73	607,437,120.04
Авто-тээврийн хэрэгсэл	75,275,000.00	87,840,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-17,637,750.00	-6,977,500.00
Машин тоног төхөөрөмж(компьютер)	596,092,832.04	715,210,380.53
Хуримтлагдсан элэгдэл	-271,811,663.80	-360,790,101.31
Тавилга, аж ахуйн эд хогшил	272,423,871.64	407,631,091.67
Хуримтлагдсан элэгдэл	-121,317,563.90	-243,851,919.17
Бусад үндсэн хөрөнгө	21,775,987.86	21,775,987.86
Хуримтлагдсан элэгдэл	-20,538,083.11	-21,141,286.54
Ном	4,501,307.00	7,740,467.00
Биет бус хөрөнгө	6,898,333.28	13,786,670.14
Програм хангамж	13,605,913.00	22,881,887.00
Хуримтлагдсан элэгдэл	-6,707,579.72	-9,095,216.86
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,353,854,016.17	1,275,182,705.67
НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,703,753.87	440,955.41
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,703,753.87	440,955.41
Өглөг	18,703,753.87	440,955.41
Ажилчидтай холбогдсон өглөг	0	397,550.91
Бараа үйлчилгээний зардлын өглөг	811,007.87	43,404.50
Бусад өглөг	17,892,746.00	0
Байгууллагад төлөх өглөг	17,892,746.00	0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,335,150,262.30	1,274,741,750.26
Засгийн газрын хувь оролцоо	1,335,150,262.30	1,274,741,750.26
Засгийн газрын оруулсан капитал	501,056,375.51	501,056,375.51
Хуримтлагдсан үр дүн	805,442,793.35	745,034,281.31
Өмнөх үеийн үр дүн	764,345,757.20	805,442,793.35
Тайлант үеийн үр дүн	41,097,036.15	-60,408,512.04
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,651,093.44	28,651,093.44
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,353,854,016.17	1,275,182,705.67

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,231,850,249.00	6,842,514,486.99
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	781,641,649.00	142,997,851.03
Өмчийн орлого	623,951,849.00	142,997,851.03
Төсөв байгууллагын өөрийн орлого	623,951,849.00	142,997,851.03
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,633,800.00	13,000,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,667,496.00	97,527,044.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	500,650,553.00	32,470,807.03
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	157,689,800.00	0.00
Хандив тусламж-гадаад	157,689,800.00	0.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,450,208,600.00	6,699,516,635.96
Улсын төсвөөс	8,450,208,600.00	6,688,471,790.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,675,259,700.00	6,561,223,670.00
Хөрөнгийн санхүүжилт	774,948,900.00	127,248,120.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	11,044,845.96
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0.00	11,044,845.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,190,753,212.85	6,896,290,749.03
УРСГАЛ ЗАРДАЛ	9,190,753,212.85	6,896,290,749.03
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,585,925,752.61	6,684,211,100.85
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,159,340,481.01	1,241,938,543.71
Үндсэн цалин	1,076,152,581.01	1,132,692,943.71
Нэмэгдэл	21,654,900.00	41,189,600.00
Унаа хоолны Хөнгөлөлт	61,533,000.00	68,056,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,529,751.12	144,937,982.75
Тэтгэврийн даатгал	137,529,751.12	144,937,982.75
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	6,780,000.00
Байрны түрээс	0.00	6,780,000.00
Хангамж, бараа материалын зардал	305,610,302.06	319,698,079.50
Бичиг хэрэг	29,811,101.70	31,621,140.00
Тээвэр, шатахуун	195,224,581.00	201,955,695.24
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,755,910.36	57,671,094.26
Ном, хэвлэл	35,818,709.00	28,450,150.00
Нормативт зардал	2,220,486.19	1,757,074.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,220,486.19	1,757,074.00
Эд хогшил, урсгал засварын зардал	357,105,050.25	41,700,000.00
Тавилга	353,705,050.25	40,634,650.00
Урсгал засвар	3,400,000.00	1,065,350.00
Томилолт, зочны зардал	2,727,541,709.68	3,019,214,080.78
Гадаад албан томилолт	1,789,629,671.40	2,105,450,550.07
Дотоод албан томилолт	217,997,315.00	185,176,981.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	719,914,723.28	728,586,549.71
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,018,709,005.20	708,285,292.60
Даатгалын үйлчилгээ	463,100.00	485,000.00
Мэдээлэл, сурталчилгааны зардал	68,720,890.00	94,610,000.00
Төлбөр хураамж болон бусад зардал	884,234,479.20	529,570,751.19
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	64,290,536.00	82,038,541.41
Холбооны суваг ашигласны хөлс	1,000,000.00	1,581,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,893,428,267.06	1,112,351,927.51
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	147,550,762.00	79,746,949.00
Төвлөрсөн арга хэмжээ	353,393,400.00	182,028,330.00
Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал	1,276,473,829.59	758,318,795.00

Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,010,275.47	92,257,853.51
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ	984,440,700.04	87,548,120.00
Дотоод эх үүсвэрээс	984,440,700.04	87,548,120.00
Төсвийн хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж	984,440,700.04	87,548,120.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	457,427,316.24	64,448,448.18
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	457,427,316.24	64,448,448.18
Төвлөрүүлэх шилжүүлэг	457,427,316.24	64,448,448.18
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	147,400,144.00	147,631,200.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	57,748,302.00	80,547,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	57,748,302.00	80,547,000.00
Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	89,651,842.00	67,084,200.00
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	89,651,842.00	67,084,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	41,097,036.15	-53,776,262.04
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	2,865,000.00
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	1,500,000.00
Хөрөнгө оруулалтын олз	0.00	1,365,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	9,497,250.00
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	9,497,250.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	41,097,036.15	-60,408,512.04

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,879,824,092.76	6,845,961,599.96
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	429,615,492.76	29,169,355.00
Өмчийн орлого	271,925,692.76	29,169,355.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	271,925,692.76	29,169,355.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,633,800.00	14,500,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	260,291,892.76	14,669,355.00
Тусламжийн орлого	157,689,800.00	0
Хандив тусламж-гадаад	157,689,800.00	0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,450,208,600.00	6,816,792,244.96
Улсын төвлөрсөн төсвөөс	8,450,208,600.00	6,688,471,790.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,675,259,700.00	6,561,223,670.00
Хөрөнгийн санхүүжилт	774,948,900.00	127,248,120.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0	128,320,454.96
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	93,902,534.96
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	34,417,920.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,753,070,760.99	6,740,153,113.73
УРСГАЛ ЗАРДАЛ	7,753,070,760.99	6,740,153,113.73
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,148,243,300.75	6,528,073,465.55
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,157,745,562.50	1,271,207,029.86
Үндсэн цалин	1,074,557,662.50	1,161,961,429.86
Нэмэгдэл	0	17,473,600.00
Унаа хоолны Хөнгөлөлт	83,187,900.00	91,772,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,731,261.76	144,937,982.75
Тэтгэврийн даатгал	136,731,261.76	144,937,982.75
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	6,780,000.00
Байрны түрээс	0	6,780,000.00
Хангамж, бараа материалын зардал	285,196,109.06	318,806,675.00
Бичиг хэрэг	26,612,504.70	30,773,140.00
Тээвэр, шатахуун	177,918,985.00	201,955,695.24
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,251,910.36	57,627,689.76
Ном, хэвлэл	36,412,709.00	28,450,150.00
Нормативт зардал	2,220,486.19	1,757,074.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,220,486.19	1,757,074.00
Эд хогшил, урсгал засварын зардал	319,418,113.25	1,065,350.00
Тавилга	316,018,113.25	0
Урсгал засвар	3,400,000.00	1,065,350.00
Томилолт, зочны зардал	2,625,355,463.40	3,019,816,713.21
Гадаад албан томилолт	1,716,696,064.40	2,106,053,182.50
Дотоод албан томилолт	217,169,605.00	185,176,981.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	691,489,794.00	728,586,549.71
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	844,731,203.00	743,608,566.73
Даатгалын үйлчилгээ	380,000.00	380,000.00
Мэдээлэл, сурталчилгааны зардал	68,720,890.00	94,610,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	83,100.00	105,000.00
Төлбөр хураамж болон бусад зардал	710,256,677.00	564,894,025.32
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	64,290,536.00	82,038,541.41

Холбооны суваг ашигласны хөлс	1,000,000.00	1,581,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,776,845,101.59	1,020,094,074.00
Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг	1,116,900,799.59	0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	147,550,762.00	79,746,949.00
Төвлөрсөн арга хэмжээ	470,000,000.00	182,028,330.00
Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал	42,393,540.00	758,318,795.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	457,427,316.24	64,448,448.18
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	457,427,316.24	64,448,448.18
Төвлөрүүлэх шилжүүлэг	457,427,316.24	64,448,448.18
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ - SOCIAL BENEFITS	147,400,144.00	147,631,200.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	57,748,302.00	80,547,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	57,748,302.00	80,547,000.00
Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	89,651,842.00	67,084,200.00
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	89,651,842.00	67,084,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,126,753,331.77	105,808,486.23
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,056,939,183.04	231,208,935.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,056,939,183.04	231,208,935.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,056,939,183.04	-231,208,935.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	69,814,148.73	-125,400,448.77
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,586,300.04	125,400,448.77
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	125,400,448.77	0

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
Үлдэгдэл	501,056,375.51	28,651,093.44	764,345,757.20	1,294,053,226.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	501,056,375.51	28,651,093.44	764,345,757.20	1,294,053,226.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	41,097,036.15	41,097,036.15
Үлдэгдэл	501,056,375.51	28,651,093.44	805,442,793.35	1,335,150,262.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	501,056,375.51	28,651,093.44	805,442,793.35	1,335,150,262.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	-60,408,512.04	-60,408,512.04
Үлдэгдэл	501,056,375.51	28,651,093.44	745,034,281.31	1,274,741,750.26

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	ЗӨРҮҮ	ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,874,804,400.00	6,735,076,535.42	2,139,727,864.58	75.89
УРСГАЛ ЗАРДАЛ	8,747,204,400.00	6,607,828,415.42	2,139,375,984.58	75.54
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,544,935,900.00	6,460,197,215.42	2,084,738,684.58	75.60
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,326,209,600.00	1,203,464,424.86	122,745,175.14	90.74
Үндсэн цалин	1,216,964,000.00	1,094,218,824.86	122,745,175.14	89.91
Нэмэгдэл цалин	17,473,600.00	17,473,600.00	0.00	100.00
Унаа хоолны Хөнгөлөлт	91,772,000.00	91,772,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,883,000.00	140,644,904.75	5,238,095.25	96.41
Тэтгэврийн даатгал	92,834,700.00	140,644,904.75	-47,810,204.75	151.50
Тэтгэмжийн даатгал	10,609,700.00	0.00	10,609,700.00	0.00
ҮОМШӨ-ний даатгал	13,262,100.00	0.00	13,262,100.00	0.00
Ажилгүйдлийн даатгал	2,652,500.00	0.00	2,652,500.00	0.00
Эрүүл мэндийн даатгал	26,524,000.00	0.00	26,524,000.00	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,800,000.00	6,780,000.00	4,020,000.00	62.78
Байрны түрээс	10,800,000.00	6,780,000.00	4,020,000.00	62.78
Хангамж, бараа материалын зардал	351,354,700.00	319,424,522.00	31,930,178.00	90.91
Бичиг хэрэг	33,854,400.00	31,230,140.00	2,624,260.00	92.25
Тээвэр, шатахуун	203,840,200.00	201,955,695.24	1,884,504.76	99.08
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	79,588,000.00	57,407,689.76	22,180,310.24	72.13
Ном, хэвлэл	34,072,100.00	28,830,997.00	5,241,103.00	84.62
Нормативт зардал	5,000,000.00	1,757,074.00	3,242,926.00	35.14
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	1,757,074.00	3,242,926.00	35.14
Эд хогшил, урсгал засварын зардал	167,898,300.00	51,831,536.00	116,066,764.00	30.87
Багаж, техник, хэрэгсэл	15,181,300.00	10,131,536.00	5,049,764.00	66.74
Тавилга	109,717,000.00	40,634,650.00	69,082,350.00	37.04
Урсгал засвар	43,000,000.00	1,065,350.00	41,934,650.00	2.48
Томилолт, зочны зардал	3,423,784,700.00	3,009,969,833.21	413,814,866.79	87.91
Гадаад албан томилолт	2,831,360,300.00	2,106,053,182.50	725,307,117.50	74.38
Дотоод албан томилолт	321,943,400.00	179,094,981.00	142,848,419.00	55.63
Зочин төлөөлөгч хүлээн авах	270,481,000.00	724,821,669.71	-454,340,669.71	267.98
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,005,328,400.00	705,954,846.60	299,373,553.40	70.22
Даатгалын үйлчилгээ	380,000.00	380,000.00	0.00	100.00
Мэдээлэл, сурталчилгааны зардал	177,200,000.00	94,610,000.00	82,590,000.00	53.39
Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	105,000.00	-105,000.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	0.00	105,000.00	0.00
Төлбөр хураамж болон бусад зардал	682,650,000.00	527,708,976.60	154,941,023.40	77.30
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	131,100,000.00	71,401,270.00	59,698,730.00	54.46
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,293,400.00	10,168,600.00	124,800.00	98.79
Холбооны суваг ашигласны хөлс	3,600,000.00	1,581,000.00	2,019,000.00	43.92
Бараа үйлчилгээний бусад зардал	2,108,677,200.00	1,020,370,074.00	1,088,307,126.00	48.39
Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	1,434,345,000.00	0.00	1,434,345,000.00	0.00
Ой тэмдэглэх зардал	150,000,000.00	0.00	150,000,000.00	0.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	173,332,200.00	80,022,949.00	93,309,251.00	46.17
Төвлөрсөн арга хэмжээ	351,000,000.00	182,028,330.00	168,971,670.00	51.86
Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал	0.00	758,318,795.00	-758,318,795.00	0.00
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	202,268,500.00	147,631,200.00	54,637,300.00	72.99

Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	110,768,500.00	80,547,000.00	30,221,500.00	72.72
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	110,768,500.00	80,547,000.00	30,221,500.00	72.72
Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	91,500,000.00	67,084,200.00	24,415,800.00	73.32
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	91,500,000.00	67,084,200.00	24,415,800.00	73.32
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	127,600,000.00	127,248,120.00	351,880.00	99.72
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	127,600,000.00	127,248,120.00	351,880.00	99.72
Тээврийн хэрэгсэл	0.00	39,700,000.00	-39,700,000.00	0.00
Бусад (Тоног төхөөрөмж)	127,600,000.00	87,548,120.00	40,051,880.00	68.61
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,874,804,400.00	6,653,192,696.82	2,221,611,703.18	74.97
Улсын төсвөөс санхүүжих	8,854,804,400.00	6,624,023,341.82	2,230,781,058.18	74.81
Улсын төсвөөс санхүүжих	8,854,804,400.00	6,624,023,341.82	2,230,781,058.18	74.81
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	20,000,000.00	29,169,355.00	-9,169,355.00	145.85
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	14,500,000.00	5,500,000.00	72.50
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14,669,355.00	-14,669,355.00	0.00
Төсвийн бусад мэдээллийн ангилал	102.00	92.00	10.00	90.20
Байгууллагын тоо	3.00	3.00	0.00	100.00
Төсвийн байгууллага	3.00	3.00	0.00	100.00
Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
Ажиллагсадын тоо	99.00	89.00	10.00	89.90
Удирдах ажилтан	17.00	14.00	3.00	82.35
Гүйцэтгэх ажилтан	82.00	75.00	7.00	91.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	81,884,191.01	-81,884,191.01	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00